

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА,  
МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ, САНГИЙН САЙДЫН  
ХАМТАРСАН ТУШААЛ

2015 оны 11 сарын 16 өдөр

Дугаар 315/4-169/309

Улаанбаатар хот

Заавар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6, Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. “Кастодианы санхүүгийн тайлан бэлтгэх, нягтлан бодох бүртгэл хөтлөх заавар”-ыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Энэхүү зааврыг 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гурав. Энэ тушаалаар батлагдсан зааврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/, Монголбанкны Хяналт шалгалтын газар /Д.Ганбат/, Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар /Х.Пүрэвсүрэн/-т тус тус даалгасугай.





## A-1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1. Кастодианы үйл ажиллагаа эрхэлж буй этгээдийн нийтлэг зориулалттай санхүүгийн тайланг бэлтгэхэд энэ зааврыг мөрдөнө.
2. Кастодианы үйл ажиллагаа эрхэлж буй этгээд энэхүү зааварт тулгуурлан дотооддоо СТОУС болон Монгол улсад мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн үндсэн зарчмуудад бүрэн нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлого, журам, дансны дэлгэрэнгүй жагсаалтыг боловсруулж мөрдөнө.
3. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд (банкны охин ба хараат компани) нь санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2012 оны 77 дугаар тушаалаар батлагдсан аж ахуйн нэгжид мөрдөх санхүүгийн тайлангийн маягт загвараар үнэн зөв бэлтгэж, толилуулна.
4. Банк кастодианы үйл ажиллагааг банкны нэгж хэлбэрээр явуулж байгаа тохиолдолд кастодианы үйлчилгээтэй холбоотой тусгаарласан мөнгөн хөрөнгө болон харилцагчийн өмнө хүлээсэн үүрэг болон балансын гадуур бүртгэлтэй харилцагчийн хөрөнгөтэй холбоотой бүртгэлийг энэхүү зааврын дагуу бүртгэх ба банкны бусад үйл ажиллагааны бүртгэлийг Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн зааврын дагуу хөтөлнө.
5. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд нь дансны үлдэгдлийн жагсаалтыг зааврын 1 дүгээр хавсралтын дагуу улирлаар бэлтгэж, дараа улирлын эхний сарын 20-ны дотор Санхүүгийн Зохицуулах Хороо (цаашид Хороо гэх)-нд хүргүүлнэ.
6. Кастодианы үйл ажиллагаа эрхлэх банк нь кастодианы үйл ажиллагааны тайланг зааврын 2 дугаар хавсралтын дагуу улирлаар бэлтгэж, дараа улирлын эхний сарын 20-ны дотор Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголбанкинд хүргүүлнэ.
7. Кастодианы үйл ажиллагаа эрхэлж буй банк, түүний охин ба хараат компани нь холбогдох журмын дагуу бэлтгэсэн эхний хагас жилийн санхүүгийн тайланг 07 дугаар сарын 20-ны өдрийн дотор, жилийн санхүүгийн тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор Хороонд хүргүүлнэ.
8. Хэрэв кастодианы үйл ажиллагаа эрхэлж буй банкны нэгдэл нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэдэг бол банкны нэгдлийн жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланг дараа оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор Хороонд хүргүүлнэ.

## A-2. КАСТОДИАНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

- 2.1. Санхүүгийн тайлангийн зорилго нь хэрэглэгчдийг эдийн засгийн шийдвэр гаргахад зориулан байгууллагын санхүүгийн байдал (хөрөнгө, өр төлбөр, эздийн өмч), санхүүгийн үр дүн (ашиг, алдагдал), мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тухай мэдээллээр хангахад оршино.
- 2.2. Санхүүгийн тайланг бэлтгэхдээ дараах ерөнхий зарчмуудыг баримтална. Үүнд:

- a) СТОУС-ыг мөрдөх. Кастодианы нягтлан бodoх бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлагнаалд СТОУС-ыг мөрдөнө.
- б) Нягтлан бodoх бүртгэлийн суурь. Кастодианы нягтлан бodoх бүртгэлийг аккруэл сууриар хөтөлнө. Нягтлан бodoх бүртгэлийн аккруэл суурь гэж мөнгө хүлээн авсан эсхүл төлсөн эсэхээс үл хамааран орлогыг олсон тухай бүрт нь хүлээн зөвшөөрч бүртгэх аргыг хэлнэ.
- в) Нягтлан бodoх бүртгэлийн үзүүлэлтийн нэгж. Нягтлан бodoх бүртгэлийн үзүүлэлтийн нэгж нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөг, мөнгө байна.
- г) Нягтлан бodoх бүртгэлийн бодлогыг тууштай мөрдөх. Кастодианы нягтлан бodoх бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлагнаалд баримталсан нягтлан бodoх бүртгэлийн бодлого, зарчмыг тууштай мөрдөнө.
- д) Үнэн зөв толилуулга. Кастодианы санхүүгийн тайлангууд нь санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв, бодитойгоор илэрхийлсэн байна. Санхүүгийн тайланд тоон болон чанарын үзүүлэлтүүдийг харгалзан, шаардлагатай бол нэмэлт тайлбар, тодруулгуудыг бэлтгэнэ.
- е) Хэлбэрээс агуулгыг илүүтэй анхаарах. Аливаа мэдээлэлд ажил гүйлгээ, үйл явдлыг зохих ёсоор тусгахын тулд мэдээллийн агуулга, бодит байдлыг харгалзан үзсэний үндсэн дээр бүртгэнэ.
- ё) Иж бүрэн байдал. Санхүүгийн тайланд тусгагдах мэдээллийн найдвартай байдлыг хангахын тулд мэдээллийг иж бүрнээр нь тусгана.
- ж) Тасралтгүй байх зарчим. Кастодиан нь санхүүгийн тайланг бэлтгэх явцад үйл ажиллагаагаа тасралтгүй явагдах чадварт үнэлэлт дүгнэлт өгнө. Кастодианыг татан буулгах, түүний үйл ажиллагааг зогсоо шийдвэр гаралаагүй тохиолдолд тасралтгүй байх зарчмын дагуу санхүүгийн тайланг тасралтгүй бэлтгэнэ.
- з) Илэрхийллийн тогтвортой байдал. Кастодианы үйл ажиллагаанд гарсан томоохон хэмжээний өөрчлөлтөөс бусад тохиолдолд санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийн илэрхийлэл болон түүний ангиллыг нэг тайлант үеэс нөгөө тайлант үед өөрчлөхгүй.
- и) Санхүүгийн мэдээлэл харьцуулагдахуйц байх. Санхүүгийн тайлангийн тоон мэдээллийг арга зүйн хувьд тайлант хугацааны тоо мэдээллийг өмнөх тайлант хугацааны мэдээлэлтэй харьцуулж бэлтгэнэ.
- й) Цаг хугацаандaa байх зарчим. Энэ нь хэрэглэгчдийн шийдвэрт нөлөөлөх боломжтой хугацаанд болон хуулиар заасан хугацаанд багтаан санхүүгийн тайланг бэлтгэж толилуулахыг ойлгоно.
- к) Цэвэр дүн гаргах. СТОУС-д шаардсан эсхүл зөвшөөрсөнөөс бусад тохиолдуудад хөрөнгө ба өр төлбөр, орлого болон зардлыг нэгтгэж, цэвэр дүнгээр тайлагнахгүй.
- 2.3. Санхүүгийн тайлангийн жил 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхэлж 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болно.

### A-3. ДАНСНЫ ЖАГСААЛТ

- 3.1. Дансны жагсаалт нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан кастодианы үйл ажиллагааны онцлогийг бүрэн тусгасан, нягтлан бodoх бүртгэлээр дамжуулан хүлээн авах мэдээллийн хэрэгцээг бүрэн хангахуйц бүртгэлийн үйл ажиллагааг СТОУС-ын жишгийн дагуу ангилсан дансны нэр болон дугаараас бүрдсэн системчилсэн жагсаалт байна.

- 3.2. Дансны дугаар хэдэн оронтой байх нь тухайн кастодианы үйл ажиллагааны цар хүрээ, онцлог, удирдлагын мэдээллийн хэрэгцээнээс хамаарна.
- 3.3. Дансыг кодчилах аргачлал нь улсын хэмжээнд нягтлан бодох бүртгэлийн мэдээллийн нэгдсэн систем бүрдүүлэх зорилгод нийцсэн байна.
- 3.4. Энэхүү зааварт нийцүүлэн үндсэн дансыг туслах дансанд хэрхэн ангилахыг кастодианы нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгээр тодорхойлж, удирдлагаар батлуулж мөрдөнө.

## **Б. ХӨРӨНГӨ**

### ***Тодорхойлолт***

Хөрөнгө гэдэг нь байгууллагын хяналтанд байгаа бөгөөд өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүсч, ирээдүйд эдийн засгийн үр өгөөж өгөх нөөц юм.

### ***Ангилал***

Санхүүгийн тайланд хөрөнгийг дараах байдлаар ангилж, толилуулна.

- Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө
- Хязгаарлагдсан мөнгөн хөрөнгө
- Бусдаас авах авлага
- Татварын авлага
- Хөрөнгө оруулалт
- Урьдчилж төлсөн тооцоо
- Үндсэн хөрөнгө
- Биет бус хөрөнгө
- Хойшлогдсон татварын хөрөнгө

### ***Хүлээн зөвшөөрөх***

Хөрөнгийн хувьд ирээдүйд эдийн засгийн үр өгөөж өгөх магадлалтай бөгөөд өртгийг бодитой тооцох боломжтой үед хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

### ***Данснаас хасах***

Хөрөнгийн бүх эрсдэл, өгөөжийг бусдад шилжүүлсэн эсхүл хөрөнгийн ашиглалтаас ирээдүйн эдийн засгийн үр өгөөж хүртэхгүй болсон үед хөрөнгийг данснаас хасч, бүртгэнэ.

### ***Үнэлгээ, хэмжэсилт***

Хөрөнгийн анхны өртөг нь тухайн хөрөнгийг олж авсан буюу худалдан авч бэлтгэсэн өдрийн бодит үнэ цэнээр тодорхойлогоно.

Хөрөнгийн дараа үеийн үнэлгээ буюу санхүүгийн тайланд толилуулах дүн нь түүний ангиллаас шалтгаалан ялгаатай зарчмаар илэрхийлэгдэнэ.

## **Б-1. МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ, ТУСГААРЛАСАН МӨНГӨН ХӨРӨНГӨ**

### ***Тодорхойлолт***

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө гэж үнэ цэнийн өөрчлөлтөөс өчүүхэн бага эрсдэлийг мэдэрдэг, түргэн борлогдох чадвартай хөрөнгийг хэлнэ. Үүнд касс дахь бэлэн мөнгө, банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, мөнгтэй адилтгах бусад хөрөнгө багтана.

Кастодиан нь харилцагчийн хадгалуулсан мөнгөн хөрөнгийг өөрийн мөнгөн хөрөнгөөс тусгаарлаж, хязгаарлагдсан буюу тусгаарласан мөнгөн хөрөнгийн дансанд бүртгэж, толилуулна.

### **Үнэлгээ, хэмжилт**

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр үнэлж, бүртгэх ба санхүүгийн тайланд хорогдуулсан өргөөр үнэлж, толилуулна.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг Монголбанкны албан ханшаар тооцон төгрөгт хөрвүүлэн хүлээн зөвшөөрөх ба төгрөг, валютаар давхар бүртгэнэ. Тайлагналын өдөр гадаад валютыг тухайн өдрийн албан ханшаар дахин үнэлэх ба ханшийн тэгшитгэлээр үссэн зөрүүг тайлант хугацааны орлого, зардлаар хүлээн зөвшөөрнө.

### **Санхүүгийн тайландаа толилуулах**

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг санхүүгийн байдлын тайландаа “Эргэлтийн хөрөнгө” бүлгийн “Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө”-өөр 1.1.1 дүгээр мөрөнд толилуулна.

Тусгаарласан мөнгөн хөрөнгийг хадгалж буй хугацааг харгалзан санхүүгийн байдлын тайландаа толилуулна. Нэг жил хүртэлх хугацаанд хадгалагдах мөнгөн хөрөнгийг “Эргэлтийн хөрөнгө” бүлгийн “Бусад эргэлтийн хөрөнгө”-өөр 1.1.8 дугаар мөрөнд толилуулна. Нэг жилээс дээш хугацаагаар хадгалагдах мөнгөн хөрөнгийг “Эргэлтийн бус хөрөнгө” бүлгийн “Бусад эргэлтийн бус хөрөнгө”-өөр 1.2.8 дугаар мөрөнд толилуулна.

### **Нягтлан бодох бүртгэл хотлогт**

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн орлогын гүйлгээ хийхэд:

Дебет: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс  
Кредит: Холбогдох данс

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн зарлагын гүйлгээ хийхэд:

Дебет: Холбогдох данс  
Кредит: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс

Харилцагч мөнгөн хөрөнгө хадгалуулахад:

Дебет: Тусгаарласан мөнгөн хөрөнгө  
Кредит: Харилцагчийн өмнө хүлээсэн үүрэг

Харилцагчийн даалгавраар мөнгөн хөрөнгийн зарлагын гүйлгээ хийхэд:

Дебет: Харилцагчийн өмнө хүлээсэн үүрэг  
Кредит: Тусгаарласан мөнгөн хөрөнгө

Харилцагч хадгалуулсан мөнгөө татан авахад:

Дебет: Харилцагчийн өмнө хүлээсэн үүрэг  
Кредит: Тусгаарласан мөнгөн хөрөнгө

Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгөнд хүү тооцож, хуримтлуулахад:

Дебет: Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага  
Кредит: Хүүгийн орлого

Хуримтлуулсан хүү төлөгдөхөд:

Дебет: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс  
Кредит: Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн ханшийн тэгшитгэлээр гадаад валютын ханш өссөн бол:

Дебет: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс

Кредит: Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн ханшийн тэгшитгэлээр гадаад валютын ханш буурсан бол:

Дебет: Гадаад валютын ханшийн зөрүүгийн гарз

Кредит: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс

## **Б.2. АВЛАГА**

### ***Тодорхойлолт***

Авлага гэж нийлүүлсэн бараа, ажил, үйлчилгээний үнэ эсхүл бусдаас авахаар хүлээн зөвшөөрөгдсөн санхүүгийн хөрөнгийн дүнг ойлгоно. Бусдаас авах авлагад харилцагчаас авах авлага, ХОМК-аас авах авлага, ногдол ашгийн авлага, хуримтлуулж тооцсон хүүгийн авлага, бусад авлага багтана. Харин татварын авлагыг тусад нь толилуулна.

### ***Үнэлгээ, хэмжилт***

Авлагыг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр үнэлж, бүртгэх ба санхүүгийн тайланд хорогдуулсан өргөөр үнэлж, толилуулна. Авлагын хорогдуулсан өртөг гэж анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс эргэн төлөлт болон эрсдэлийн санг хассан цэвэр дүнг хэлнэ.

Авлагын эрсдэлийн сан буюу үнэ цэнийн бууралтыг СТОУС-ын дагуу тооцож, үнэлнэ.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн авлагыг Монголбанкны албан ханшаар тооцон төгрөгт хөрвүүлэн хүлээн зөвшөөрөх ба төгрөг, валютаар давхар бүртгэнэ. Тайлагналын өдөр гадаад валютыг тухайн өдрийн албан ханшаар дахин үнэлэх ба ханшийн тэгшитгэлээр үүссэн зөрүүг тайлант хугацааны орлого, зардлаар хүлээн зөвшөөрнө.

### ***Санхүүгийн тайланд толилуулах***

Бусдаас авах авлагыг санхүүгийн байдлын тайланд “Эргэлтийн хөрөнгө” бүлгийн “Дансны авлага”-аар 1.1.2 дугаар мөрөнд толилуулна.

Татвар, НДШ-ийн авлагыг санхүүгийн байдлын тайланд “Эргэлтийн хөрөнгө” бүлгийн “Татвар, НДШ-ийн авлага”-аар 1.1.3 дугаар мөрөнд толилуулна.

### ***Нягтлан бодох бүртгэл хотилот***

Авлагыг хүлээн зөвшөөрч, бүртгэхэд:

Дебет: Авлагын данс

Кредит: Холбогдох данс

Авлага төлөгдөхөд:

Дебет: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс

Кредит: Авлагын данс

Авлагад эрсдэлийн сан байгуулахад:

Дебет: Эрсдэлийн сангийн зардал

Кредит: Авлагын эрсдэлийн сангийн данс

Авлагын эрсдэлийн сангаас авлагыг хаасан бол:

Дебет: Авлагын эрсдэлийн сангийн данс

Кредит: Авлагын данс

## **Б.3. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ**

### ***Тодорхойлолт***

Хөрөнгө оруулалтанд кастодианы өөрийн хөрөнгөөр худалдан авч, эзэмшиж буй үнэт цаас, дериватив хэрэгслийг бүртгэнэ. Үүнийг үнэт цаасны төрлөөр ангилж, бүртгэнэ.

Хөрөнгө оруулалт нь үнэт цаасаар оруулсан хөрөнгө оруулалт болон охин, хараат компани, хамтарсан үйлдвэрт оруулсан хөрөнгө оруулалтаас бүрдэнэ.

### ***Үнэт цаасаар оруулсан хоронго оруулалтын ангилал ба үнэлгээ, хэмжилт***

Үнэт цаасаар оруулсан хөрөнгө оруулалтыг дөрөв ангилж, бүртгэнэ.

- Арилжааны буюу ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэх үнэт цаас
- Хугацааны эцэс хүргэл эзэмших үнэт цаас
- Зээл ба авлага гэж ангилсан үнэт цаас
- Борлуулахад бэлэн үнэт цаас

*Арилжааны буюу ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэх үнэт цаас*

Ашиг олох зорилгоор худалдан аваад, богино хугацаанд эргүүлэн худалдаж ашиг олох зориулалттай өрийн ба өмчийн үнэт цаасыг арилжааны үнэт цаас гэж ангилна. Мөн дараах нөхцөлд үнэт цаасыг ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэх үнэт цаасанд ангилж, бүртгэнэ: (а) үнэт цаасыг холбогдох хөрөнгө, өр төлбөрийн бүртгэлийн нийцлийг хангах үүднээс энэ ангилалд бүртгэсэн үед; эсхүл (б) санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг нийцүүлэн удирдаж, бодит үнэ цэнээр үнэлсэн. Дериватив санхүүгийн хэрэгсэл энэ ангилалд багтана.

Арилжааны үнэт цаас буюу ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэх үнэт цаасыг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр үнэлнэ. Энэ ангиллын үнэт цаасны арилжаатай холбоотой аливаа төлбөр, шимтгэлийг шууд зардалд бүртгэнэ.

Энэ ангиллын үнэт цаасыг тодорхой хугацааны давтамжтайгаар бодит үнэ цэнээр нь дахин үнэлэх ба бодит үнэ цэнийн өсөлт, бууралтыг үнэлгээний орлого, зардалд бүртгэнэ.

Бодит үнэ цэн гэж ажил гүйлгээг бүртгэх өдөр зах зээлийн оролцогчдын хооронд байнга хийгдэх арилжаагаар хөрөнгийг худалдан авах буюу өр төлбөрт шилжүүлэх үнэ юм. Бодит үнэ цэнийг тодорхойлоход ашиглагдах мэдээллийн эх сурвалж гурван түвшинд хуваагдана. Үүнд:

- Нэгдүгээр түвшний мэдээлэл нь хөрөнгө, өр төлбөрийн идэвхитэй зах зээлийн залруулаагүй үнэ юм. Хөрөнгө, өр төлбөрийн арилжааны давтамж, хэмжээний хувьд хүрэлцээтэй бөгөөд үндэслэлтэй мэдээллээр тогтмол хангах зах зээлийг идэвхтэй зах зээл гэнэ.
- Хоёрдугаар түвшний мэдээлэл нь хөрөнгө, өр төлбөртэй холбоотойгоор шууд болон шууд бусаар олж авах боломжтой бөгөөд нэгдүгээр түвшний мэдээллээс бусад мэдээлэл юм. Үүнд дараах мэдээлэл багтана:
  - Ижил төстэй хөрөнгө, өр төлбөрийн идэвхтэй зах зээлийн үнэ
  - Яг ижил эсхүл ижил төстэй хөрөнгө, өр төлбөрийн идэвхитэй бус зах зээлийн жишиг үнэ
  - Хөрөнгө, өр төлбөрийн зах зээлийн үнэ ханшийн бус мэдээлэл, тухайлбал хүүгийн түвшин, өгөөжийн муруй, таамаглаж буй түвшин, өрийн хэрэгсэлийн хүүгийн зөрүүний түвшин
  - Зах зээлийн нийтлэг мэдээллээс гарган авсан эсхүл тэдгээр мэдээллийг ашиглан корреляц болон бусад аргаар тооцоолж гаргасан мэдээлэл
- Гуравдугаар түвшний мэдээлэл нь хөрөнгө, өр төлбөртэй холбоотойгоор шууд олдохгүй мэдээлэл юм. Өөрөөр хэлбэл илэрхий бус, ихээхэн залруулга, тохируулга хийх шаардлагатай мэдээллийн эх сурвалжийг гуравдугаар түвшинд хамруулна.

### *Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас*

Тодорхой, тогтмол төлбөрийн хуваарътай, тогтсон хугацаанд дуусгавар болох үнэт цаасыг нэрлэсэн хугацааг нь хүртэл эзэмшихээр шийдвэрлэсэн бол “Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас” гэж ангилана.

Хугацааны эцэс хүртэл эзэмшихээр ангилсан үнэт цаасыг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэн дээр холбогдох шууд зардлыг нэмсэн дүнгээр бүртгэнэ.

Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаасыг санхүүгийн тайланд хорогдуулсан өртгөөр үнэлж, толилуулна.

Үнэт цаасны хорогдуулсан өртгийг тооцохдоо анх хүлээн зөвшөөрсөн үнээс үндсэн төлбөрийн төлөлтийг хасч, үр ашигт хүүгийн аргаар тооцоолсон урамшууллын хорогдолыг хасах эсхүл хямдруулалтын хорогдолыг нэмнэ.

Хугацааны эцэс хүртэл эзэмшихээр ангилсан үнэт цаасны ангиллыг тусгайлан заасан нөхцөл байдлаас бусад тохиолдолд өөрчлөхийг хориглоно. Өөрөөр хэлбэл, үнэт цаасны дуусгавар хугацаа буюу буцаан худалдан авах өдөрт ойртсон ба хүүгийн түвшинд гарах өөрчлөлт нь тухайн санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэхгүй; төлөвлөгөөт буюу урьдчилсан байдлаар тухайн санхүүгийн хөрөнгийн үлдэгдэл бараг төлөгдсөн; банкнаас шалтгаалаагүй хүчин зүйл нөлөөлсөн, тохиолдохоор хүлээгдээгүй, дахин давтагдахгүй үйл явдал тохиолдсон; үнэт цаасыг анхны удаад хүлээн зөвшөөрөхдөө хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаасаар ангилах үеийн төлөвлөгөөгүй нөхцөл байдал үүссэн бол хугацааны эцэс хүртэл эзэмшихтэй холбоотой удирдлагын зорилгыг өөрчлөлгүйгээр энэ ангиллын үнэт цаасыг худалдаж болно. Тухайлбал: үнэт цаас гаргагчийн санхүүгийн чадвар мэдэгдэхүйц хэмжээгээр муудсан, хууль тогтоомжинд нэмэлт өөрчлөлт орсон, компанийн нэгдэл үүссэн эсхүл хуваагдсан.

Хэрэв хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаасыг хугацааг нь дуустал эзэмшилгүйгээр харин зориулалтыг нь өөрчилж, бусдад худалдан борлуулах буюу шилжүүлсэн бол ийм арилжаа хийгдсэн тайлант үеэс хойш хоёроос доошгүй жил ямарваа үнэт цаасыг “Хугацааны эцэс хүртэл эзэмших” ангилаар ангилах эрхгүй болно.

### *Зээл ба авлага гэж ангилсан үнэт цаас*

Зээл ба авлага гэж ангилсан үнэт цаас гэдэг нь идэвхтэй зах зээлийн жишиг үнэгүй бөгөөд тодорхой мөнгөн дүн бүхий, дериватив бус санхүүгийн хөрөнгийг хэлэх ба үүнд арилжаалах зориулалттай эзэмшиж буй болон борлуулах зориулалттай хөрөнгийг хамруулахгүй.

### *Борлуулахад бэлэн үнэт цаас*

Дээрх гурван ангилалд багтаагүй үнэт цаасыг “борлуулахад бэлэн үнэт цаас”-аар ангилана.

Борлуулахад бэлэн үнэт цаасыг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэн дээр холбогдох шууд зардлыг нэмсэн дүнгээр бүртгэнэ.

Санхүүгийн тайланд борлуулахад бэлэн үнэт цаасыг бодит үнэ цэнээр нь үнэлж, толилуулах ба бодит үнийн өсөлт, бууралтыг үнэт цаасны дахин үнэлгээний сан дансанд хуримтлуулна. Үнэт цаасыг бусдад худалдах буюу шилжүүлэн данснаас хасах үед дахин үнэлгээний сангийн үлдэгдлийг тайлант үеийн орлого, зардалд шилжүүлэн бүртгэнэ.

### *Охин, хараат компани, хамтарсан үйлдвэрт оруулсан хоронго оруулалтын үнэлгээ, хэмжислийн*

Охин компани гэж компанийн хяналтанд буй аж ахуйн нэгжийг хэлнэ. Өгөөж хүртэхийн тулд охин компанийн санхүү ба үйл ажиллагааг бодлогын түвшинд удирдах эрх мэдлийг хяналт гэнэ. Компани охин компанийд оруулсан хөрөнгийн хэмжээгээрээ ашиг хүртэх эрх үүссэн бөгөөд охин компани дахь эрх мэдлээрээ дамжуулан ашигт нөлөөлөх боломжтой үед охин компанийд хяналтаяа тогтоосон гэж үзнэ.

Хөрөнгө оруулагчийн охин компани эсхүл хамтын хөрөнгө оруулалтын аль ч биш бөгөөд хөрөнгө оруулагчийн зүгээс мэдэгдэхүйц нөлөө бүхий аж ахуйн нэгжийг хараат компани гэнэ. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны бодлогын түвшний шийдвэр гаргахад оролцох эрхтэй боловч хяналт тогтоогоогүй бол мэдэгдэхүйц нөлөө гэнэ.

Хоёр ба түүнээс дээш оролцогч талууд үйл ажиллагаанд тавих хяналтыг гэрээгээр тохиролцож санхүүгийн болон үндсэн үйл ажиллагааны талаар шийдвэр гаргахад хамтын хэлцэл байгуулж, хамтын хяналтандаа байлгах аж ахуйн нэгжийг хамтын хяналттай аж ахуйн нэгж гэнэ.

Хараат компани ба хамтын хяналттай компанид оруулсан хөрөнгийг оруулалтыг өмчийн аргаар бүртгэнэ. Өмчийн арга гэдэг нь хөрөнгө оруулалтыг эхэлж өртгөөр нь хүлээн зөвшөөрч, дараагийн тайлант үед хараат ба хамтын хяналттай компанийн эздийн өмчид гарсан өөрчлөлтийг банкны эзэмшилийн хувиар тохируулан бүртгэх аргыг хэлнэ.

Охин компанид оруулсан хөрөнгө оруулалтыг өртгөөр эсхүл бодит үнэ цэнээр хэмжиж, бүртгэнэ.

Эзэмшиж буй өмчийн үнэт цаастай холбогдуулан ногдол ашиг авах эрх үүсч, авах магадлалтай гэж үзвэл ногдол ашгийн орлогыг хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

Урт хугацаат өрийн үнэт цаасны хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргаар тооцоолж, хүлээн зөвшөөрнө.

### *Хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралт*

Хөрөнгө оруулалтанд СТОУС-ын дагуу эрсдэлийн сан байгуулна.

### *Санхүүгийн тайланд толилуулах*

Хөрөнгө оруулалтыг санхүүгийн байдлын тайланд толилуулахдаа хугацаа, зорилгыг харгалзана. Хөрөнгө оруулалтыг нэг жил хүртэлх хугацаанд эзэмших эсхүл арилжааны зориулалттай бол “Эргэлтийн хөрөнгө” бүлгийн “Бусад санхүүгийн хөрөнгө”-өөр 1.1.5 дугаар мөрөнд толилуулна. Нэг жилээс дээш хугацаагаар эзэмших санхүүгийн хөрөнгө болон охин, хараат компани, хамтарсан үйлдвэрт оруулсан хөрөнгө оруулалтыг “Эргэлтийн бус хөрөнгө” бүлгийн “Урт хугацаат хөрөнгө оруулалт”-аар 1.2.4 дүгээр мөрөнд толилуулна.

### *Нягтлан бодох бүртгэл хотолт*

Санхүүгийн хэрэгслийг худалдан авч, хөрөнгө оруулахад:

Дебет: Хөрөнгө оруулалтын холбогдох данс  
Кредит: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс

Дахин үнэлгээний үр дүнд үнэт цаасны үнэ ёсч, олз хүлээн зөвшөөрсөн бол:

Дебет: Хөрөнгө оруулалтын холбогдох данс  
Кредит: Санхүүгийн хэрэгслийн үнэлгээний олз

Дахин үнэлгээний үр дүнд үнэт цаасны үнэ буурч, гарз хүлээн зөвшөөрсөн бол:

Дебет: Санхүүгийн хэрэгслийн үнэлгээний гарз  
Кредит: Хөрөнгө оруулалтын холбогдох данс

Өрийн хэрэгслийн хүүг хуримтлуулахад:

Дебет: Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага  
Кредит: Хүүгийн орлого

Хуримтлуулж тооцсон хүү төлөгдөхөд:

Дебет: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс  
Кредит: Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага

Зарласан ногдол ашгийг хуримтлуулахад:

Дебет: Ногдол ашгийн авлага  
Кредит: Ногдол ашгийн орлого

Хуримтлуулсан ногдол ашиг төлөгдөхөд:

Дебет: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс  
Кредит: Ногдол ашгийн авлага

Өрийн хэрэгслийн хугацаа дуусч, эргэн төлөгдөхөд:

Дебет: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс  
Кредит: Хөрөнгө оруулалтын холбогдох данс

Санхүүгийн хэрэгслийг борлуулахад:

Дебет: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс  
Кредит: Хөрөнгө оруулалтын холбогдох данс

Хэрэв санхүүгийн хэрэгслийг ашигтай борлуулсан бол:

Дебет: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс  
Кредит: Санхүүгийн хэрэгслийн арилжааны олз  
Кредит: Хөрөнгө оруулалтын холбогдох данс

Хэрэв санхүүгийн хэрэгслийг алдагдалтай борлуулсан бол:

Дебет: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс  
Дебет: Санхүүгийн хэрэгслийн арилжааны гарз  
Кредит: Хөрөнгө оруулалтын холбогдох данс

Үнэ цэн буурсан хөрөнгө оруулалтанд эрсдэлийн сан байгуулахад:

Дебет: Эрсдэлийн сангийн зардал  
Кредит: Эрсдэлийн сангийн данс

Эрсдэлийн сангаас хөрөнгийг хаасан бол:

Дебет: Эрсдэлийн сангийн данс  
Кредит: Хөрөнгө оруулалтын холбогдох данс

#### **Б.4. УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТООЦОО**

##### **Тодорхойлолт**

Урьдчилж төлсөн тооцоонд бусдаас авах бараа, ажил, үйлчилгээнд төлсөн урьдчилгаа төлбөр, барьцаа хөрөнгө зэргийг бүртгэнэ.

##### **Үнэлгээ, хэмжилт**

Урьдчилж төлсөн тооцоог өртгөөр буюу төлсөн мөнгөн дүнгээр үнэлж, толилуулна.

##### **Данснаас хасах**

Урьдчилж төлсөн зардлыг хэрэгжсэн үед зарлагадаж бүртгэнэ.

##### **Санхүүгийн тайланд толилуулах**

Урьдчилж төлсөн тооцоог санхүүгийн байдлын тайланд “Эргэлтийн хөрөнгө” бүлгийн “Урьдчилж төлсөн зардал/тооцоо”-гоор 1.1.7 дугаар мөрөнд толилуулна.

##### **Нягтлан бодох бүртгэл хотилт**

Дараа тооцоо хийхээр урьдчилгаа төлбөр шилжүүлэхэд эсхүл барьцаа хөрөнгө байршуулахад:

Дебет: Урьдчилж төлсөн тооцоо

Кредит: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс

Зардлыг хүлээн зөвшөөрөхдөө:

Дебет: Холбогдох зардлын данс

Кредит: Урьдчилж төлсөн тооцоо

Барьцаа хөрөнгийг эргүүлэн авахад:

Дебет: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс

Кредит: Урьдчилж төлсөн тооцоо

## **Б.5. ҮНДСЭН ХӨРӨНГӨ, БИЕТ БУС ХӨРӨНГӨ**

### ***Тодорхойлолт***

Үндсэн хөрөнгө нь ажил, үйлчилгээ үзүүлэх, эсхүл захиргааны зориулалтаар ашиглах зорилгоор байгууллагын өмчлөлд байгаа бөгөөд нэгээс дээш жилээр ашиглагдах биет хөрөнгө юм. Үндсэн хөрөнгөнд газрын сайжруулалт, барилга, байгууламж, тоног төхөөрөмж, компьютер хэрэгсэл гэх мэт хөрөнгө хамрагдана.

Биет бус хөрөнгө нь биет шинж чанаргүй, тодорхойлж болохуйц, мөнгөн бус хөрөнгө юм. Үүнд программ хангамж, патент хамрагдана.

### ***Үнэлгээ, хэмжилт***

Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийг худалдан авсан бол анхны өртөг нь хөнгөлөлт, буцаалтыг хассан худалдан авалтын үнэ, гаалийн татвар, буцаан олгогдохгүй худалдааны татвар болон тухайн хөрөнгийг ашиглахад бэлэн болгож байршуулах ба ашиглахад шаардлагатай нөхцлийг хангахад шууд хамаарах зардал зэргээс бүрдэнэ.

Үндсэн хөрөнгийг өөрөө барьж байгуулсан бол хөрөнгийн анхны өртөг нь барилгын материал, шууд холбогдох цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж, талбай бэлтгэх зардал, бусад холбогдох нэмэлт зардал болон барилгын ажлыг гэрээгээр гүйцэтгэгчид төлөх төлбөр зэргээс бүрдэнэ. Энэ тохиолдолд хөрөнгийн өртөгт НББОУС 23-д заасан шалгуурыг хангасан хүүгийн зардлыг оруулах ба харин хэвийн бус хорогдол гэж үзэх зардлыг оруулахгүй.

Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийг өртгийн загвар ба дахин үнэлгээний загварын аль тохиromжтойгоор бүртгэж, санхүүгийн тайланд толилуулна.

Хөрөнгийг бүртгэх өртгийн загвар гэдэг нь дээрх эргэлтийн бус хөрөнгийг санхүүгийн тайланд толилуулахдаа анхны өртгөөс хуримтлагдсан элэгдэл, үнэ цэнийн бууралтыг хассан цэвэр дүнгээр буюу өртгөөр үнэлж илэрхийлэхийг ойлгоно. Үндсэн хөрөнгийн элэгдэл байгуулах бодлого нь татварын хуулиар тогтоосон хувь хэмжээнээс зөрүүтэй бол зөрүүг хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрөөр бүртгэж, тайлagnана.

Хөрөнгийг бүртгэх дахин үнэлгээний загвар гэдэг нь хөрөнгийг хуримтлагдсан элэгдэл, үнэ цэнийн бууралтыг тусгасан бодит үнэ цэнийг илтгэх дүнгээр үнэлэхийг ойлгоно. Энэ тохиолдолд тодорхой хугацааны давтамжтайгаар дахин үнэлгээг үргэлжлүүлэн хийх шаардлагатай болно. Дахин үнэлгээг хийх давтамж нь хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс шалтгаална. Хөрөнгийн дансны үнэ ба бодит үнэ цэнийн хооронд материаллаг зөрүү үүсч байвал зайлшгүй дахин үнэлгээг хийнэ.

### ***Санхүүгийн тайланд толилуулах***

Үндсэн хөрөнгийг санхүүгийн байдлын тайланд “Эргэлтийн бус хөрөнгө” бүлгийн “Үндсэн хөрөнгө”-өөр 1.2.1 дүгээр мөрөнд толилуулна.

Биет бус хөрөнгийг санхүүгийн байдлын тайланд “Эргэлтийн бус хөрөнгө” бүлгийн “Биет бус хөрөнгө”-өөр 1.2.2 дугаар мөрөнд толилуулна.

## *Нягтлан бодох бүртгэл хотолт*

Эргэлтийн бус хөрөнгө худалдан авсан бол анхны өртгөөр нь:

Дебет: Холбогдох эргэлтийн бус хөрөнгийн данс  
Кредит: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс

Хөрөнгөнд элэгдэл байгуулахдаа:

Дебет: Элэгдлийн зардал  
Кредит: Холбогдох хуримтлагдсан элэгдэл

Дахин үнэлгээний үр дүнд хөрөнгийн дансны үнэ нэмэгдсэн нөхцөлд дахин үнэлгээний нэмэгдэлд бүртгэнэ:

Дебет: Холбогдох эргэлтийн бус хөрөнгийн данс  
Кредит: Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл

Дахин үнэлгээний үр дүнд хөрөнгийн дансны үнэ буурсан бол бууралтыг үндсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын зардалд бүртгэнэ:

Дебет: Хөрөнгийн дахин үнэлгээний гарз  
Кредит: Холбогдох эргэлтийн бус хөрөнгийн данс

Хэрэв эргэлтийн бус хөрөнгийг алдагдалтай худалдсан бол:

Дебет: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс (худалдан авсан дүнгээр)  
Дебет: Хөрөнгө борлуулсны гарз (зөрүүгээр)  
Кредит: Холбогдох эргэлтийн бус хөрөнгийн данс (дансны үнээр)

Хэрэв эргэлтийн бус хөрөнгийг ашигтай худалдсан бол:

Дебет: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс (худалдан авсан дүнгээр)  
Кредит: Хөрөнгө борлуулсны олз (зөрүүгээр)  
Кредит: Холбогдох эргэлтийн бус хөрөнгийн данс (дансны үнээр)

## **V. ОР ТӨЛБӨР**

### *Тодорхойлолт*

Өнгөрсөн үйл ажиллагааны үр дүнд бий болсон, эдийн засгийн өгөөжийг өөртөө агуулж буй нөөцийн гадагшлах урсалаар төлөгдөхөөр хүлээгдэж буй бөгөөд байгууллагын бусдын өмнө хүлээх үүрэг хариуцлагыг өр төлбөр гэнэ.

### *Ангилал*

Санхүүгийн тайланд өр төлбөрийг дараах байдлаар ангилик, толилуулна.

- Бусдад өгөх өглөг
- Харилцагчийн өмнө хүлээсэн үүрэг
- Татварын өглөг
- Урьдчилж орсон орлого
- Нөөц (өр төлбөр)
- Хойшлогдсон татварын өглөг

### *Хүлээн зөвшөөрөх*

Хүлээсэн үүргээ билүүлснээр эдийн засгийн өгөөж буурах магадлалтай бөгөөд дүнг нь бодитой хэмжих боломжтой тохиолдолд өр төлбөрийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч, толилуулна.

## *Данснаас хасах*

Гэрээ, хэлцлээр хүлээсэн үүргийг бүрэн биелүүлсэн, гэрээний хугацаа дуусгавар болсон, эсхүл үүргэс чөлөөлөгдсөн нөхцөлд өр төлбөрийг данснаас хасч, бүртгэнэ.

### **В.1. БУСДАД ӨГӨХ ӨГЛӨГ**

#### *Тодорхойлолт*

Бусдад өгөх өглөг гэж бусад этгээдэд мөнгө ба бусад санхүүгийн хөрөнгийг шилжүүлэхээр хүлээсэн гэрээний үүргийг ойлгоно. Үүнд ногдол ашгийн өглөг, төвлөрсөн хадгаламжийн байгууллагад өгөх өглөг, төлбөр тооцооны байгууллагад өгөх өглөг багтана.

#### *Үнэлгээ, хэмжилт*

Өглөгийг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр үнэлж, бүртгэх ба санхүүгийн тайланд хорогдуулсан өртгөөр үнэлж, толилуулна.

#### *Санхүүгийн тайланд толилуулах*

Бусдад өгөх өглөгийг санхүүгийн байдлын тайланд “Богино хугацаат өр төлбөр” бүлгийн “Дансны өглөг”-өөр 2.1.1.1 дүгээр мөрөнд толилуулна.

#### *Нягтлан бодох бүртгэл хотолт*

Зардлыг хуримтлуулж, өглөг хүлээн зөвшөөрч бүртгэхэд:

Дебет: Холбогдох зардлын данс

Кредит: Бусдад өгөх өглөг

Өглөгийг төлж барагдуулахад:

Дебет: Бусдад өгөх өглөг

Кредит: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс

### **В.2. ХАРИЛЦАГЧИЙН ӨМНӨ ХҮЛЭЭСЭН ҮҮРЭГ**

#### *Тодорхойлолт*

Харилцагчийн өмнө хүлээсэн үүрэг гэж харилцагчийн байршуулж, хадгалуулсан мөнгөн хөрөнгийг бүртгэх дансыг хэлнэ. Харилцагчийн өмнө хүлээсэн үүргийг харилцагч тус бүрээр данс нээж, бүртгэнэ.

#### *Үнэлгээ, хэмжилт*

Харилцагчийн харилцахыг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр үнэлж, бүртгэх ба санхүүгийн тайланд хорогдуулсан өртгөөр үнэлж, толилуулна.

Харилцагчийн өмнө хүлээсэн үүргийг өртгөөр үнэлж, толилуулна.

#### *Санхүүгийн тайланд толилуулах*

Харилцагчийн өмнө хүлээсэн үүргийг санхүүгийн байдлын тайланд толилуулахдаа харилцагчийн хадгалуулсан хөрөнгийн хугацаа буюу хүлээсэн үүрэг дуусгавар болох хугацааг харгалзана. Нэг жил хүртэлх хугацаатай үүргийг “Богино хугацаат өр төлбөр” бүлгийн “Бусад богино хугацаат өр төлбөр”-өөр 2.1.1.10 дугаар мөрөнд толилуулна. Нэг жилээс дээш хугацаатай үүргийг “Урт хугацаат өр төлбөр” бүлгийн “Бусад урт хугацаат өр төлбөр”-өөр 2.1.2.4 дүгээр мөрөнд толилуулна.

#### *Нягтлан бодох бүртгэл хотолт*

Харилцагч данс нээлгэж, орлогын гүйлгээ хийхэд:

Дебет: Хязгаарлагдсан мөнгөн хөрөнгө  
Кредит: Харилцагчийн өмнө хүлээсэн үүрэг

Харилцагч дансаа хаах эсхүл зарлагын гүйлгээ хийхэд:

Дебет: Харилцагчийн өмнө хүлээсэн үүрэг  
Кредит: Хязгаарлагдсан мөнгөн хөрөнгө

### **В.3. УРЬДЧИЛЖ ОРСОН ОРЛОГО**

#### *Тодорхойлолт*

Урьдчилж орсон орлого гэж ажил, үйлчилгээг гүйцэтгэж дуусаагүй тул хойшлуулан бүртгэсэн урьдчилгаа төлбөрийг хэлнэ. Ажил, үйлчилгээг гүйцэтгэсний дараа орлогыг хүлээн зөвшөөрч, урьдчилж орсон орлогыг бууруулна.

#### *Үнэлгээ, хэмжилт*

Урьдчилж орсон орлогыг төлөгдсөн дүнгээр үнэлж, толилуулна.

#### *Санхүүгийн тайландаа толилуулах*

Урьдчилж орсон орлогыг санхүүгийн байдлын тайландаа “Богино хугацаат өр төлбөр” бүлгийн “Урьдчилж орсон орлого”-оор 2.1.1.8 дугаар мөрөнд толилуулна.

#### *Нягтлан бодох бүртгэл хотолт*

Урьдчилгаа төлбөр төлөгдөхөд:

Дебет: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс  
Кредит: Урьдчилж орсон орлого

Орлогыг хүлээн зөвшөөрч бүртгэхэд:

Дебет: Урьдчилж орсон орлого  
Кредит: Холбогдох орлогын данс

### **В.4. НӨӨЦ (ӨР ТӨЛБӨР)**

#### *Тодорхойлолт*

Кастодиан өөрийн буруутай үйлдлийн улмаас бусдад хохирол учруулсан, томоохон бүтцийн өөрчлөлт хийх, алдагдалтай гэрээ байгуулах болон тэдгээртэй адилтгах зүйлсэд зориулсан нөөц байгуулж болно.

Алдагдалтай гэрээ гэдэг нь гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд гарах зайлсхийх боломжгүй зардал нь гэрээний дагуу хүртэх эдийн засгийн өгөөжөөс давах нөхцөлтэй хийгдсэн гэрээг хэлнэ.

Нөөц гэж хугацаа, дүн нь тодорхойгүй өр төлбөрийг хэлнэ.

Болзошгүй өр төлбөр нь өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүссэн бөгөөд ирээдүйн тодорхой бус үйл явдал тохиолдсоноор эсхүл үл тохиолдсоноор оршин байх нь баталгаажих эсхүл өнгөрсөн үйл явдлын улмаас үүссэн өнөөгийн үүрэг боловч өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангахгүй байгаа гэрээг хэлнэ.

#### *Хүлээн зөвшөөрөх*

Нөөцийг дараах нөхцөлд хүлээн зөвшөөрч, бүртгэнэ:

- Өнгөрсөн үйл явдлын үр дүнд хуулиар хүлээсэн болон үүсмэл үүрэг хүлээсэн;
- Үүргийг биелүүлэхийн тулд төлбөр барагдуулах магадлалтай;

- Өр төлбөрийн дүнг найдвартай тооцоолох боломжтой.

Болзошгүй өр төлбөрийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч бүртгэг, толилуулахгүй ба харин тэнцлийн гадуур хүлээж болзошгүй үүргээр бүртгэж, тайлagnана.

Зардлыг харгалзах зориулалтын дагуу байгуулсан нөөцдөд бүртгэх ба нөөцийг зөвхөн анх бүртгэж байсан үеийн зориулалтаар зарцуулна.

### **Үнэлгээ, хэмжилт**

Нэг жилийн тодор төлөгдөх нөөцийг төлөх дүнгийн хамгийн сайн тооцооллыг үндэслэн үнэлж бүртгэх бол нэг жилийн дотор төлөгдөхгүй нөөцийг ирээйдүн мөнгөн төлбөрийн өнөөгийн үнэ цэнээр дискаунтчилж, үнэлнэ.

Тайлант хугацаа бүрийн эцэст нөөцийн дүнг нягталж, тухайн үеийн хамгийн сайн тооцооллыг харуулсан тохируулгыг хийнэ.

### **Санхүүгийн тайланд толилуулах**

Нөөцийг санхүүгийн байдлын тайланд толилуулахдаа түүний хугацааг харгалзана. Нэг жил хүртэлх хугацаатай нөөцийг “Богино хугацаат өр төлбөр” бүлгийн “Нөөц /өр төлбөр/-өөр 2.1.1.9 дүгээр мөрөнд толилуулна. Нэг жилээс дээш хугацаатай нөөцийг “Урт хугацаат өр төлбөр” бүлгийн “Нөөц /өр төлбөр/-өөр 2.1.2.2 дугаар мөрөнд толилуулна.

### **Нягтлан бодох бүртгэл хотилт**

Болзошгүй зардал буюу гарзыг хүлээн зөвшөөрч бүртгэхэд:

Дебет: Холбогдох зардлын данс

Кредит: Нөөц

Байгуулсан нөөцөөс зориулалтын дагуу зарцуулахад:

Дебет: Нөөц

Кредит: Холбогдох хөрөнгийн данс

Үйл ажиллагааны болзошгүй эрсдэлийн сан байгуулахад:

Дебет: Үйл ажиллагааны эрсдэлийн сангийн зардал

Кредит: Нөөц

Үйл ажиллагааны болзошгүй эрсдэлийн сангаас зориулалтын дагуу зарцуулахад:

Дебет: Нөөц

Кредит: Холбогдох хөрөнгийн данс

## **Г. ЭЗДИЙН ӨМЧ**

### **Тодорхойлолт**

Эздийн өмч нь кастодианы бүх өр төлбөрийг барагдуулсны дараа үлдэх хөрөнгө юм.

### **Ангилал**

Санхүүгийн байдлын тайланд эздийн өмчийг дараах байдлаар ангилж, толилуулна.

- Хувь нийлүүлсэн хөрөнгө
- Хуримтлагдсан ашиг, алдагдал
- Эздийн өмчийн бусад дансд

### **Санхүүгийн тайланд толилуулах**

Хувь нийлүүлсэн хөрөнгө буюу гаргасан хувьцааны нэрлэсэн үнийн дүнг санхүүгийн байдлын тайланд “Эздийн өмч” бүлгийн “Өмч”-өөр харгалзах 2.3.1, 2.3.2 эсхүл 2.3.3 дугаар мөрөнд толилуулна.

Хуримтлагдсан ашиг, алдагдлыг санхүүгийн байдлын тайланд “Эздийн өмч” бүлгийн “Хуримтлагдсан ашиг”-аар 2.3.9 дүгээр мөрөнд толилуулна.

Эздийн өмчийн бусад дансдын дүнг санхүүгийн байдлын тайланд “Эздийн өмч” бүлгийн “Эздийн өмчийн бусад хэсэг”-ээр 2.3.8 дугаар мөрөнд толилуулна.

### ***Нягтлан бодох бүртгэл хотолт***

Кастодианыг үүсгэн байгуулах үед хувь нийлүүлсэн хөрөнгийн дүнгээр:

Дебет: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс

Кредит: Хувь нийлүүлсэн хөрөнгө

Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг зарласан бол:

Дебет: Хуримтлагдсан ашиг, алдагдал

Кредит: Ногдол ашгийн өглөг

Зарласан ногдол ашгийг төлөхөд:

Дебет: Ногдол ашгийн өглөг

Кредит: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс

Хуримтлагдсан ашгаас тусгай зориулалт бүхий сан байгуулсан бол:

Дебет: Хуримтлагдсан ашиг, алдагдал

Кредит: Холбогдох сангийн данс (Эздийн өмчийн бусад дансд)

Тусгай зориулалт бүхий сангаас зориулалтын дагуу хөрөнгө зарцуулсан бол:

Дебет: Холбогдох сангийн данс

Кредит: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс

## **Д. ОРЛОГО БА ЗАРДАЛ**

### ***Тодорхойлолт***

Орлого нь тайлант хугацаанд хөрөнгийн дотогшлох урсгал болон хөрөнгийн сайжруулалт, эсхүл хувьцаа эзэмшигчдээс оруулсан хөрөнгөтэй холбоогүйгээр эздийн өмчийг нэмэгдүүлж, өр төлбөрийг бууруулах хэлбэрээр гарах эдийн засгийн үр өгөөжийн ёсөлт юм.

Олз, гарз гэж кастодианы үйл ажиллагааны явцад үүссэн, бодит ба бодит бус боловч орлого, зардлын тодорхойлолтонд нийцэх бусад зүйлсийг ойлгоно. Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз, гарз, санхүүгийн хэрэгслийн үнэлгээний ба арилжааны олз, гарз зэргийг тусад нь бүртгэж, санхүүгийн тайланд толилуулна. Эдгээрээс бусад олз, гарзыг бусад орлого, зардалд тайлagnана.

Зардал нь хувьцаа эзэмшигчдэд олгосон хуваарилалттай холбоогүй, эздийн өмчийг бууруулж буй хөрөнгийн хорогдол буюу гадагшлах урсгал эсхүл өр төлбөр үүсэх зэрэг хэлбэрээр тайлант хугацаанд бий болсон эдийн засгийн өгөөжийн бууралт юм.

### ***Ангилал***

Санхүүгийн тайланд орлогыг дараах байдлаар ангилж, толилуулна.

- Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого
- Хүүгийн орлого
- Бусад орлого

Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого гэрээний дагуу байгууллагын үзүүлсэн үйлчилгээний хураамж, шимтгэлийг аккруэл сууриар хүлээн зөвшөөрч, бүртгэсэн орлого хамрагдана.

Санхүүгийн тайланд зардлыг дараах байдлаар ангилж, толилуулна.

- Борлуулалт, маркетингийн зардал
- Ерөнхий, удирдлагын зардал
- Санхүүгийн зардал
- Бусад зардал

#### ***Хүлээн зөвшөөрөх***

Орлого, зардал, олз, гарзын дүнг бодитой тооцон гаргах боломжтой бөгөөд ажил гүйлгээний эцсийн өгөөжийг хүртэх магадлалтай эсхүл ажил гүйлгээний үр дунд эдийн засгийн өгөөж буурсан нөхцөлд хүлээн зөвшөөрнө.

#### ***Үнэлгээ, хэмжилт***

Орлогыг хүлээн авсан мөнгө эсхүл үүссэн авлагын бодит үнэ цэнээр үнэлнэ.

Зардлыг төлсөн мөнгө эсхүл үүссэн өглөгийн бодит үнэ цэнээр үнэлнэ.

#### ***Санхүүгийн тайланд толилуулах***

Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлогын цэвэр дүнг орлогын дэлгэрэнгүй тайланд “Борлуулалтын орлого”-оор 1 дүгээр мөрөнд толилуулна.

Хүүгийн орлогыг орлогын дэлгэрэнгүй тайланд “Хүүний орлого”-оор 5 дугаар мөрөнд толилуулна.

Бусад орлогыг орлогын дэлгэрэнгүй тайланд “Бусад орлого”-оор 8 дугаар мөрөнд толилуулна.

Борлуулалт, маркетингийн зардлыг орлогын дэлгэрэнгүй тайланд 9 дүгээр мөрөнд, ерөнхий, удирдлагын зардлыг 10 дугаар мөрөнд, санхүүгийн зардлыг 11 дүгээр мөрөнд, бусад зардлыг 12 дугаар мөрөнд толилуулна.

#### ***Нягтлан бодох бүртгэл хотолот***

Ажил, үйлчилгээ үзүүлээд төлбөрийг авахад:

Дебет: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс

Кредит: Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого

Ажил, үйлчилгээ үзүүлэсэн боловч төлбөрийг хараахан аваагүй бол авлага хүлээн зөвшөөрнө:

Дебет: Бусдаас авах авлага

Кредит: Холбогдох орлогын данс

Гарсан зардлыг мөнгөөр төлөхөд:

Дебет: Холбогдох зардлын данс

Кредит: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс

Зардлыг хуримтлуулж, өглөгөөр хүлээн зөвшөөрч бүртгэхэд:

Дебет: Холбогдох зардлын данс

Кредит: Бусдад өгөх өглөг

## **Д-1. Орлогын албан татвар**

### ***Тодорхойлолт***

Тайлант хугацааны татвар гэдэг нь холбогдох хууль тогтоомжийн дагуу тайлант хугацааны татвар ногдуулах орлогоос тооцоолж гаргасан, төлөх ёстой орлогын албан татварын дүн юм. Тайлант хугацааны татварыг давуулан төлсөн буюу илүү төлсөн бол татварын авлага дансанд, харин төлөөгүй бол татварын өглөг дансанд бүртгэнэ.

Хойшлогдсон татварын өглөг гэдэг нь татвар ногдох түр зөрүүгээс шалтгаалан ирээдүйн тайлант хугацаанд төлөх орлогын албан татварын өглөгийн дүн юм. Хойшлогдсон татварын хөрөнгө гэдэг нь хасагдах түр зөрүү, татварын алдагдлыг дараагийн тайлант үерүү шилжүүлэх, ашиглагдаагүй татварын хөнгөлөлтийг дараагийн үерүү шилжүүлэхтэй тус тус холбоотойгоор ирээдүйн тайлант үед нөхөгдөх орлогын татварын дүнг хэлнэ.

### ***Үиэлгээ, хэмжилт***

Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг тэдгээр нь ирээдүйд бий болох буюу хэрэгжих магадлалтай тохиолдолд л зөвхөн хүлээн зөвшөөрнө. Татварын түр зөрүүг бүртгэхэд үүссэн хойшлогдсон татварын өглөг, хойшлогдсон татварын хөрөнгө данс нь тодорхой хугацааны дараа нөхөгдөж үлдэгдэлгүй болно.

### ***Санхүүгийн тайланд толилуулах***

Тайлант хугацааны татварын илүү төлөлтийг санхүүгийн байдлын тайланд “Эргэлтийн хөрөнгө” бүлгийн “Татвар, НДШ-ийн авлага”-аар 1.1.3 дугаар мөрөнд толилуулна.

Тайлант хугацааны татварын өглөгийг санхүүгийн байдлын тайланд “Богино хугацаат өр төлбөр” бүлгийн “Татварын өр”-өөр 2.1.1.3 дугаар мөрөнд толилуулна.

Тайлант хугацаанд ногдуулсан татварын зардлыг орлогын дэлгэрэнгүй тайланд “Орлогын татварын зардал”-аар 19 дүгээр мөрөнд толилуулна.

Хойшлогдсон татварын хөрөнгийг санхүүгийн байдлын тайланд “Эргэлтийн бус хөрөнгө” бүлгийн “Хойшлогдсон татварын хөрөнгө”-өөр 1.2.6 дугаар мөрөнд толилуулна.

Хойшлогдсон татварын өр төлбөрийг санхүүгийн байдлын тайланд “Урт хугацаат өр төлбөр” бүлгийн “Хойшлогдсон татварын өр”-өөр 2.1.2.3 дугаар мөрөнд толилуулна.

### ***Нягтлан бодох бүртгэл хотилт***

Орлогын албан татварыг урьдчилж төлөхөд татварын авлагад бүртгэнэ:

Дебет: Татварын авлага

Кредит: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс

Татварын хувь хэмжээгээр тооцоолсон тайлант хугацаанд хамаарах татварыг ААНОАТ-ын өглөгт бүртгэнэ:

Дебет: Татварын зардал

Кредит: Татварын өглөг

Хувьцаа эзэмшигчдэд хуваарилсан ногдол ашигт татвар ногдуулж, суутган авсан бол:

Дебет: Ногдол ашгийн өглөг

Кредит: Татварын өглөг

Хууль тогтоомжийн дагуу хувь хүнд хамаарах орлогод татвар ногдуулж, бүртгэхэд:

Дебет: Холбогдох данс

Кредит: Татварын өглөг

Татварын авлага, өглөгийг хааж цэвэршүүлэхэд:

Дебет: Татварын өглөг

Кредит: Татварын авлага

Татварын түр зөрүүгийн нелөөгөөр хойшлогдсон татварын хөрөнгө үүсэхэд:

Дебет: Хойшлогдсон татварын хөрөнгө

Кредит: Татварын өглөг

Хойшлогдсон татварын хөрөнгийг бууруулж тохируулахад:

Дебет: Татварын зардал

Кредит: Хойшлогдсон татварын хөрөнгө

Татварын түр зөрүүгийн нелөөгөөр хойшлогдсон татварын өглөг үүсэхэд:

Дебет: Татварын зардал

Кредит: Хойшлогдсон татварын өглөг

Хойшлогдсон татварын өглөгийг татварын зөрүүгээр бууруулж тохируулахад:

Дебет: Хойшлогдсон татварын өглөг

Кредит: Татварын өглөг

## E. ТЭНЦЛИЙН ГАДУУРХ ДАНСД

### *Тодорхойлолт*

Тэнцлийн гадуурх дансд нь санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаагүй боловч дэлгэрүүлж бүртгэн, тодруулах шаардлагатай зүйлсийг бүртгэх дансд юм.

### *Ангилал*

Тэнцлийн гадуурх дансдыг дараах байдлаар ангиljж, толилуулна. Үүнд:

- Хүлээсэн болзошгүй үүрэг
- Харилцагчийн хадгалуулсан хөрөнгө
- Бусад дансд

### *Хүлээсэн болзошгүй үүрэг*

Хүлээсэн болзошгүй үүргийн дансанд гэрээ, хэлцлийн үндсэн дээр бусдын өмнө кастодианы хүлээсэн үүргийг бүртгэнэ.

Кастодиан бусдын өмнө үүрэг хүлээсэн бол хүлээсэн үүргийн нийт дүнгээр “Хүлээсэн болзошгүй үүрэг”-ийн дансанд орлогодоно. Хүлээсэн үүргээ биелүүлсэн, үүргээс чөлөөлөгдсөн, үүрэг хүлээсэн хугацаа дуусгавар болсон, үүргийг цуцалсан зэрэг шалтгаанаар хүлээсэн үүрэг дуусгавар болоход энэ данснаас зарлагадана.

### *Харилцагчийн хадгалуулсан хөрөнгө*

Кастодиан үйлчилгээ үзүүлэхээр хөрөнгө авах бүртээ хүлээн авсан хөрөнгийн төрлөөс хамаарч холбогдох дансадад тэнцлийн гадуурх зүйлс болгон бүртгэнэ.

Харилцагч үнэт цаасыг эргүүлэн татах хүсэлт гаргавал холбогдох дүнг тэнцлийн гадуурх данснаас зарлагадна.

Харилцагчийн байршуулсан хөрөнгийг үнэт цаасны төрлөөр ангиljж, тоо ширхэгээр болон мөнгөн дүнгээр бүртгэнэ.

### *Бусад дансд*

Тэнцлийн гадуурх бусад дансадад дээр дурдсанаас бусад хөрөнгийг нэр төрлөөр нь ангиljж, тоо ширхэгээр бүртгэнэ. Шаардлагатай нөхцөлд мөнгөн дүнгээр давхар бүртгэж болно.

Дээрх хөрөнгийг хүлээн зөвшөөрч санхүүгийн тайланд толилуулахад тэнцлийн гадуурх дансыг орлогодох ба данснаас хасахад тэнцлийн гадуурх данснаас зарлагадана.

### **Санхүүгийн тайланд толилуулах**

Тэнцлийн гадуурх дансын талаарх мэдээллийг санхүүгийн тайлангийн тодруулгын “Бусад эргэлтийн бус хөрөнгө”, “Өр төлбөр”, “Болзошгүй хөрөнгө ба өр төлбөр” зэрэг холбогдох хэсэгт тайлбарлаж тодруулна.

## **ӵ. КАСТОДИАНЫ ХАРИЛЦАГЧИЙН ДАНСД**

### **Тодорхойлолт**

Харилцагчийн дансын тэнцэл нь кастодианы харилцагчдын мөнгөн хөрөнгө, үнэт цаасыг тусгаарлан бүртгэж, тайлагнах зорилготой дансд юм.

### **Ангилал**

Харилцагчийн дансын тэнцэл хоёр хэсгээс бүрдэнэ. Үүнд актив дансд буюу кастодианы хадгалж буй үнэт цаас, бусад хөрөнгийг хадгалж буй газраар харуулсан үлдэгдэл, пассив дансд буюу кастодианы харилцагч бүрээр нээсэн нэрийн дансд хамрагдана.

Актив дансдыг дараах байдлаар ангилж, толилуулна:

- Төвлөрсөн хадгаламжийн байгууллага дахь үнэт цаас
- Кастодиан дахь үнэт цаас
- Гадаадын кастодианд хадгалагдаж байгаа үнэт цаас

Пассив дансдыг дараах байдлаар ангилж, толилуулна:

- Харилцагчийн эзэмшилд байгаа хөрөнгө
- Глобал кастодиан банкны эзэмшилд байгаа хөрөнгө
- Хөрөнгө оруулалтын сангийн эзэмшилд байгаа хөрөнгө
- Бусад харилцагчийн эзэмшилд байгаа хөрөнгө

### **Бүртгэл, үнэлгээ**

Актив дансадад харилцагчийн хадгалуулсан хөрөнгийн шинж чанарыг харгалzan ангилж, бүртгэнэ.

Пассив дансадад харилцагчийн төрлүүдээр ангилж, бүртгэнэ.

Актив дансын үлдэгдлийн нийлбэр нь пассив дансын нийт үлдэгдэлтэй тэнцуу байна.

Харилцагчийн дансын тэнцэлийг кастодианы хадгалж буй үнэт цаас, бусад хөрөнгийн хувьд болон харилцагч нэг бүрээр бэлтгэж болно.

Харилцагчийн дансын тэнцэл дээрх харилцагчийн эзэмшлийн эрх болон шилжилтийн гүйлгээ нь үнэт цаасны too ширхэгээр болон мөнгөн дүн (үнэт цаасны өртөг) -ээр хийгдэнэ.

Харилцагчийн дансын тэнцэл дэх харилцагчийн эзэмшлийн үнэт цаасыг давхар бичилтийн зарчмаар бүртгэнэ. Өөрөөр хэлбэл гүйлгээг актив тал буюу үнэт цаасыг хадгалж буй газраар бүртгэхийн зэрэгцээ пассив данс болох үнэт цаасны эзэмшигчдийн нэрийн дансанд давхар бүртгэж, толилуулна.

Хэрэв үнэт цаас гаргасан компани дампуурсан бол уг үнэт цаасыг эргүүлэн татах албан ёсны шийдвэрт үндэслэн харилцагчийн эзэмшиж буй үнэт цаасыг зарлагадана.

Эмхэтгэсэн гүйлгээ баланс, дэлгэрэнгүй гүйлгээ баланс, нийт баланс болон дэлгэрэнгүй үлдэгдлэл баланс гэх мэт тайлангуудыг кастодианы бүртгэлийн програм хангамжийг ашиглан бэлтгэж болно.

Кастодианы бүртгэлийн програм хангамж нь дараах үйлдлүүдийг хийх боломжтой байна:

- Үнэт цаасны арилжааны гүйлгээ /DVP эсхүл DFP/

- Үнэт цаасны дебит / кредит гүйлгээ /орлого, зарлага/
- Компанийн үйл ажиллагаа (corporate action). Үүнд:
  - Ногдол ашиг /банкны баланс дээрх харилцагчийн нэрийн дансанд бүртгэх/
  - Бондын купоны болон үндсэн төлбөр /банкны баланс дээрх харилцагчийн нэрийн дансанд бүртгэх/
  - Үнэт цаас хуваах
  - Үнэт цаас хөрвүүлэх
- Шимтгэл авах
- Мэдээллийн шинж чанартай гүйлгээ
- Шаардлагатай тайлангууд гаргах
- Шаардлагатай SWIFT форматын мэдээлэл хүлээн авах болон үүсгэх
- Үнэт цаасны ханш оруулах
- Өдөр өндөрлөх

#### *Санхүүгийн тайланд толшуулах*

Кастодианы харилцагчийн дансдын мэдээллийг санхүүгийн тайлангийн тодруулгын “Бусад эргэлтийн бус хөрөнгө”, “Өр төлбөр”, “Болзошгүй хөрөнгө ба өр төлбөр” зэрэг холбогдох хэсэгт тайлбарлаж тодруулна.

~oOo~

“Кастодианы санхүүгийн тайллан бэлтгэх, нягтлан бодох бүртгэл хөтлөх заавар”-ын 1 дүгээр хавсралт

### Кастодианы дансны жагсаалт

д/д	Дансны бүлэг, нэр	Дансны код	Үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	1XXXX	
2	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	10000-11000	
	Касс дахь бэлэн мөнгө	10100	
	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах	11200	
	Мөнгөтэй адилтгах хөрөнгө	11300	
3	Тусгаарласан мөнгөн хөрөнгө	12000	
	Харилцагчийн хадгалуулсан мөнгөн хөрөнгө	12100	
	Бусад тусгаарласан хөрөнгө	12200	
4	Бусдаас авах авлага	13000	
	Харилцагчаас авах авлага	13100	
	Хөрөнгө оруулалтын менежментий компаниас авах авлага	13200	
	Ногдол ашгийн авлага	13300	
	Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	13400	
	Бусад авлага	13500	
	Авлагын эрсдэлийн сан	13600	
5	Татварын авлага	14000	
	ААНОАТ-ын авлага	14010	
	ХХОАТ-ын авлага	14020	
	НӨАТ-ын авлага	14030	
	Бусад татварын авлага	14040	
6	Хөрөнгө оруулалт	15000	
	Арилжааны буюу ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэх үнэт цаас	15100	
	Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас	15200	
	Зээл ба авлага гэж ангилсан үнэт цаас	15300	
	Борлуулахад бэлэн үнэт цаас	15400	
	Хараат компани, хамтарсан үйлдвэрт оруулсан хөрөнгө оруулалт	15500	
	Охин компанийд оруулсан хөрөнгө оруулалт	15600	
	Эрсдэлийн сан	15700	
7	Үндсэн хөрөнгө	16000	
	Урьдчилгаа төлбөр	16100	
	Урьдчилж төлсөн зардал	16200	
	Бусад	16300	
8	Газрын сайжруулалт	17000	
	Анхны өртөг	17100	
	Хуримтлагдсан элэгдэл, үнэ цэнийн бууралт	17110	
	Барилга, байгууламж	17120	
	Анхны өртөг	17200	
	Хуримтлагдсан элэгдэл, үнэ цэнийн бууралт	17210	
	Тоног, төхөөрөмж	17220	
	Анхны өртөг	17300	
	Хуримтлагдсан элэгдэл, үнэ цэнийн бууралт	17310	
	Компьютер, хэрэгсэл	17320	
	Анхны өртөг	17400	
	Хуримтлагдсан элэгдэл, үнэ цэнийн бууралт	17410	
	Бусад	17420	
	Анхны өртөг	17500	
	Хуримтлагдсан элэгдэл, үнэ цэнийн бууралт	17510	
		17520	

д/д	Дансны бүлэг, нэр	Дансны код	Үлдэгдэл
10	Биет бус хөрөнгө	18000	
	Программ хангамж	18100	
	Анхны өртөг	18110	
	Хуримтлагдсан хорогдол, унэ цэнийн бууралт	18120	
	Патент	18200	
	Анхны өртөг	18210	
	Хуримтлагдсан хорогдол, унэ цэнийн бууралт	18220	
	Бусад биет бус хөрөнгө	18300	
	Анхны өртөг	18310	
	Хуримтлагдсан хорогдол, унэ цэнийн бууралт	18320	
11	Хойшлогдсон татварын хөрөнгө	19000	
	ӨР ТӨЛБӨР	3XXXX	
12	Бусад өгөх өглөг	31000	
	Ногдол ашигийн өглөг	31100	
	Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	31200	
	Төвлөрсөн хадгаламжийн байгууллагад өгөх өглөг	31300	
	Төлбөр тооцооны байгууллагад өгөх өглөг	31400	
	Бусад өглөг	31500	
13	Харилцагчийн өмнө хүлээсэн үүрэг	32000	
	Хөрөнгө оруулалтын сан	32100	
	Монгол Улсад бүртгэлтэй	32110	
	Гадаадад бүртгэлтэй	32120	
	Глобал кастодиан банкны хөрөнгө	32200	
	Бусад санхүүгийн байгууллагын хөрөнгө	32300	
	Монгол Улсад бүртгэлтэй	32310	
	Гадаадад бүртгэлтэй	32320	
	Санхүүгийн бус байгууллагын хөрөнгө	32400	
	Монгол Улсад бүртгэлтэй	32410	
	Гадаадад бүртгэлтэй	32420	
	Иргэн	32500	
	Оршин суугч	32510	
	Оршин суугч бус	32520	
14	Татварын өглөг	33000	
	ААНОАТ-ын өглөг	33010	
	ХХОАТ-ын өглөг	33020	
	НӨАТ-ын өглөг	33030	
	Бусад татварын өглөг	33040	
15	Урьдчилж орсон орлого	34000	
16	Нөөц (өр төлбөр)	35000	
17	Хойшлогдсон татварын өглөг	36000	
	ЭЗДИЙН ӨМЧ	4XXXX	
18	Хувь нийлүүлсэн хөрөнгө	41000	
19	Хуримтлагдсан ашиг, алдагдал	42000	
20	Эздийн өмчийн бусад дансд	43000	
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	43100	
	Үнэт цаасны дахин үнэлгээний сан	43200	
	Бусад	43300	
	ОРЛОГО	5XXXX	
21	Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	51000	
	Үндсэн үйлчилгээний шимтгэл	51100	
	Бусад үйлчилгээний шимтгэл	51200	

д/д	Дансны бүлэг, нэр	Дансны код	Үлдэгдэл
22	Хүүгийн орлого	52000	
23	Бусад орлого	53000	
	ЗАРДАЛ	60000	
24	Борлуулалт, маркетингийн зардал	61000	
	Хураамж, шимтгэлийн зардал	61010	
	Цалин хөлс, нэмэгдэл	61020	
	НДШ-ийн зардал	61030	
	Сургалт	61040	
	Элэгдэл, хорогдол	61050	
	Түрээс	61060	
	Ашиглалтын зардал	61070	
	Бичиг хэргийн зардал	61080	
	Харуул, аюулгүй байдлын зардал	61090	
	Харилцаа, холбооны зардал	61100	
	Санхүүгийн зардал	61110	
	Мэдээллийн технологийн зардал	61120	
	Бусад	61130	
25	Ерөнхий, удирдлагын зардал	62000	
	Хураамж, шимтгэлийн зардал	62010	
	Цалин хөлс, нэмэгдэл	62020	
	НДШ-ийн зардал	62030	
	Сургалт	62040	
	Элэгдэл, хорогдол	62050	
	Түрээс	62060	
	Ашиглалтын зардал	62070	
	Бичиг хэргийн зардал	62080	
	Харуул, аюулгүй байдлын зардал	62090	
	Харилцаа, холбооны зардал	62100	
	Санхүүгийн зардал	62110	
	Мэдээллийн технологийн зардал	62120	
	Зохицуулах үйлчилгээний хөлс	62130	
	Даатгалын зардал	62140	
	Үйл ажиллагааны эрсдэлийн сангийн зардал	62150	
	Бусад	62160	
26	Санхүүгийн зардал	63000	
27	Бусад зардал	64000	
28	ОЛЗ, ГАРЗ	7XXXX	
	Гадаад валютын ханшийн зөруугийн олз, гарз	71000	
	Санхүүгийн хэрэгслийн үнэлгээний олз, гарз	72000	
	Санхүүгийн хэрэгслийн арилжааны олз, гарз	73000	
	Бусад олз, гарз	74000	
29	Орлогын албан татварын зардал	81000	
	Тайлант үеийн орлогын албан татварын зардал	81100	
	Хойшлогдсон татварын зардал	81200	
30	Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	82000	
	ТЭНЦЛИЙН ГАДУУРХ ДАНСД	91XXX-93XXX	
31	Хулээсэн болзошгүй үүрэг	91000	
32	Харилцагчийн хадгалуулсан хөрөнгө	92000	
33	Бусад дансд	93000	
	КАСТОДИАНЫ ХАРИЛЦАГЧДЫН ДАНСД		

д/д	Дансны бүлэг, нэр	Дансны код	Үлдэгдэл
	<b>АКТИВ ДАНСД:</b>	95XXX	
34	Төвлөрсөн хадгаламжийн байгууллага дахь үнэт цаас	95100	
	Засгийн газрын өрийн хэрэгсэл	95110	
	Засгийн газрын баталгаатай өрийн хэрэгсэл	95120	
	Аймаг, нийслэлийн Засаг даргын гаргасан өрийн хэрэгсэл	95130	
	Хувьцаат компанийн хувьцаа	95140	
	Компанийн өрийн хэрэгсэл	95150	
	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	95160	
	Гадаадын үнэт цаас	95170	
	Бусад өрийн хэрэгсэл	95180	
	Бусад өмчийн хэрэгсэл	95190	
35	Кастодиан дахь үнэт цаас	95200	
	Компанийн өрийн хэрэгсэл	95210	
	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	95220	
	Гадаадын үнэт цаас	95230	
	Бусад өрийн хэрэгсэл	95240	
	Бусад өмчийн хэрэгсэл	95250	
36	Гадаадын кастодианд хадгалагдаж байгаа үнэт цаас	95300	
	Компанийн өрийн хэрэгсэл	95310	
	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	95320	
	Гадаадын үнэт цаас	95330	
	Бусад өрийн хэрэгсэл	95340	
	Бусад өмчийн хэрэгсэл	95350	
	<b>ПАССИВ ДАНСД:</b>	96XXX	
37	Хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө	96100	
	Монгол Улсад бүртгэлтэй	96110	
	Гадаадад бүртгэлтэй	96120	
38	Глобал кастодиан банкны хөрөнгө	96200	
39	Бусад санхүүгийн байгууллагын хөрөнгө	96300	
	Монгол Улсад бүртгэлтэй	96310	
	Гадаадад бүртгэлтэй	96320	
40	Санхүүгийн бус байгууллагын хөрөнгө	96400	
	Монгол Улсад бүртгэлтэй	96410	
	Гадаадад бүртгэлтэй	96420	
41	Иргэн	96500	
	Оршин суугч	96510	
	Оршин суугч бус	96520	

“Кастодианы санхүүгийн тайлан бэлтгэх, нягтлан бодох бүртгэл хөтлөх заавар”-ын 2 дугаар хавсралт

### Кастодианы үйл ажиллагааны тайлан

д/д	Дансны бүлэг, нэр	Дансны код	Үлдэгдэл
	ОРЛОГО		
1	Кастодианы үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого		
2	Бусад орлого		
	ЗАРДАЛ		
3	Хураамж, шимтгэлийн зардал		
4	Цалин хэлс, нэмэгдэл		
5	НДШ-ийн зардал		
6	Сургалт		
7	Элэгдэл, хорогдол		
8	Түрээс		
9	Ашиглалтын зардал		
10	Бичиг хэргийн зардал		
11	Харуул, аюулгүй байдлын зардал		
12	Харилцаа, холбооны зардал		
13	Санхүүгийн зардал		
14	Мэдээллийн технологийн зардал		
15	Зохицуулах үйлчилгээний хэлс		
16	Даатгалын зардал		
17	Бусад зардал		
18	Кастодианы үйл ажиллагааны цэвэр ашиг, алдагдал		
	КАСТОДИАНЫ ХАРИЛЦАГЧДЫН ДАНСД		
	АКТИВ ДАНСД:		
19	Харилцагчийн хадгалуулсан мөнгөн хөрөнгө		
20	Төвлөрсөн хадгаламжийн байгууллага дахь үнэт цаас Засгийн газрын өрийн хэрэгсэл Засгийн газрын баталгаатай өрийн хэрэгсэл Аймаг, нийслэлийн Засаг даргын гаргасан өрийн хэрэгсэл Хувьцаат компанийн хувьцаа Компанийн өрийн хэрэгсэл Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас Гадаадын үнэт цаас Бусад өрийн хэрэгсэл Бусад өмчийн хэрэгсэл		
21	Кастодиан дахь үнэт цаас Компанийн өрийн хэрэгсэл Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас Гадаадын үнэт цаас Бусад өрийн хэрэгсэл Бусад өмчийн хэрэгсэл		
22	Гадаадын кастодианд хадгалагдаж байгаа үнэт цаас Компанийн өрийн хэрэгсэл Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас Гадаадын үнэт цаас Бусад өрийн хэрэгсэл Бусад өмчийн хэрэгсэл		
	ПАССИВ ДАНСД:		
23	Хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө		

	Монгол Улсад бүртгэлтэй		
	Гадаадад бүртгэлтэй		
24	Глобал кастодиан банкны хөрөнгө		
25	Бусад санхүүгийн байгууллагын хөрөнгө		
	Монгол Улсад бүртгэлтэй		
	Гадаадад бүртгэлтэй		
26	Санхүүгийн бус байгууллагын хөрөнгө		
	Монгол Улсад бүртгэлтэй		
	Гадаадад бүртгэлтэй		
27	Иргэн		
	Оршин суугч		
	Оршин суугч бус		